

Төрийн дугаар ... 2436

ОУХОН АЙМГИЙН
ЗАСГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
ХУУГСАР ЧУЗИ
Хулбар олон улсын тамирчын усэг

Лев
19 оны 11 сарын 21-ний өдөр

Төрийн албаны зөвлөлийн
2019 оны 7 дугаар сарын 16-ны өдрийн
40 дүгээр тогтоолын 5 дугаар хавсралт

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан
шинэчлэн боловсруулсан

Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон
Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг
баталсан огноо:

Байгууллагын нэр:

Орхон аймгийн Баян-Өндөр сумын
Засаг даргын Тамгын газар

Албан тушаалын нэр:

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Байгаль орчны асуудал хариуцсан
мэргэжилтэн

Туслах түшмэл, Т3-3

Ажлын цаг:

Ажлын байрны албан ёсны байршил:

Ажлын өдөр 8 цаг

Орхон аймгийн Баян-Өндөр сумын
Засаг даргын Тамгын газрын байр

Хөдөлмерийн нөхцөл:

Онцгой нөхцөл:

Хэвийн

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ


Албан тушаалын зорилго:

Байгаль орчны талаарх хууль тогтоомж, бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг
нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах, гүйцэтгэлийн үр дүнг сумын Засаг
даргын Тамгын газрын даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

- Байгаль орчныг хамгаалах хууль тогтоомж, аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэрийг орон нутагт зохион байгуулах, биелэлтийг хангах.
- Байгаль орчны хяналтын улсын байцаагчийн эрх, үүргийг хэрэгжүүлж ажиллах.
- Байгалийн нөөц баялгийг зохистой ашиглахад төр, иргэн аж ахуй нэгж байгууллагын үйл ажиллагааг уялдуулан, арга зүй удирдлагаар хангаж ажиллах.
- Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах - Х Шийдвэрлэх -Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	<p>1. Байгаль орчныг хамгаалах хууль тогтоомж, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах, хууль тогтоомж, түүнд нийцуулэн гаргасан дүрэм журмыг чанд сахин биелүүлэх.</p> <p>2. Хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хяналт шалгалт хийж, зөрчлийг арилгуулах ажлыг зохион байгуулах.</p> <p>3. Хууль тогтоомж зөрчиж, байгаль орчинд хохирол учруулсан аж ахуйн нэгж, байгууллагын лиценз, зөвшөөрөл, байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулах эрхийг хүчингүй болгуулах, үйл ажиллагааг түр болон бүр мөсөн зогсох саналаа тухайн эрх олгосон байгууллагад тавьж шийдвэрлүүлэх.</p> <p>4. Байгаль орчны тухай хууль тогтоомж зөрчсөн шийдвэр гаргасан байгууллага, албан тушаалтны шийдвэрийг хүчингүй болгохыг шаардах, эсхүл дээд шатны байгууллагад гомдол гаргаж шийдвэрлүүлэх.</p>	<p>Хууль тогтоомжид заасан чиг үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулсан байна.</p> <p>Хяналт шалгалт хуулийн дагуу хийгдсэн байна.</p> <p>Хууль тогтоомж зөрчсөн үйл ажиллагааг таслан зогсоож, зөрчлийг арилгах арга хэмжээ авсан байна.</p> <p>Хууль тогтоомж зөрчсөн шийдвэрийг хүчингүй болгуулах арга хэмжээ авсан байна.</p>	<p>Г, Х</p> <p>Х, Г</p> <p>Г</p> <p>Г</p>
	1. Хууль тогтоомж, стандарт зөвшөөрөгдөх хэмжээг зөрчиж байгаль орчинд хортой нөлөөлөл	Хууль тогтоомж, стандартыг иргэн, таих, газар хуулийн этгээдэд	ОХОН АИМГИЙН ОНДОР СҮМНҮН СТАРТЫГ ИРГЭН, ТАИХ, ГИН ГАЗАР ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД




2 дугаар зорилтын хүрээнд	<p>үзүүлсэн иргэн, аж ахуйн нэгжийг уг зөрчил арилгахыг шаардах, зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу үйл ажиллагааг зогсох;</p> <p>2.Хяналт шалгалтад шаардагдах бичиг баримт, бусад мэдээ баримтыг холбогдох иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаар гаргуулж, нэгтгэх, дүгнэлт хийх;</p> <p>3.Хяналт шалгалтад шаардлагатай сорьц, дээжийг шинжлүүлж холбогдох арга хэмжээ авах;</p> <p>4.Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянах явцад тухайн иргэний болон тээврийн хэрэгсэлийн баримт бичгийг шалгах, зөрчил илэрсэн тохиолдолд баримт бичиг, хууль бусаар агнасан, түүсэн, бэлтгэсэн, олборлосон, байгалийн баялаг, ашигласан техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлийг хурааж, Зөрчлийн тухай хууль зөрчсөн хувь хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулах, албадлагын арга хэмжээ авах.</p>	<p>мөрдүүлсэн байна.</p> <p>Хуулийн хугацаанд холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлсэн байна.</p> <p>Сорьц дээжийг стандартын дагуу хийгдсэн байна.</p>	Г Х, Г Х, Г
3 дугаар зорилтын хүрээнд	<p>1.Байгаль орчныг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, хяналт тавих үйл ажиллагаанд иргэдийг татан оролцуулах, тэдний идэвх санаачилгыг өрнүүлэх, зөвлөн туслах ажлыг зохион байгуулах, хамтран ажиллах.</p> <p>2.Байгаль хамгаалагчийн ажлыг шалгах, заавар зөвлөгөө өгөх, хэрэгжилтийг хангуулах, гүйцэтгэлд хяналт тавих, үр дүнг тооцож удирдлагуудад танилцуулах.</p> <p>4.Байгаль орчны чиглэлийн эрх зүйн болон бодлогын бичиг баримтын хэрэгжилтийг хангах чиглэлээр байгаль хамгаалагчийн ажлыг чиглүүлэх.</p> <p>5.Байгалийн баялаг ашиглахтай холбогдсон иргэдийн мэдээ, мэдээллийн дагуу шалгалт хийх, холбогдох арга хэмжээ авах.</p>	<p>Иргэн, хуулийн этгээдийн оролцоо нэмэгдсэн байна.</p> <p>Байгаль хамгаалагчийн ажлын үзүүлэлт дээшилсэн байна.</p> <p>Тайлбар, лавлагаа, зөвлөмж нь хуульд нийцсэн байх, мэдээлэл бодитой байна.</p>	Г Х, Г Х, Г



4 дүгээр зорилтын хүрээнд	1.Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, дүрэм, журам, стандартыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллах.	Хууль тогтоомж хэрэгжүүлэх арга хэмжээ авсан байна.	Г
	2.Албан хэргийг эрхлэн хөтөлж, баримт бичгийг архивт шилжүүлэх.	Албан хэргийн стандартын дагуу хөтөлсөн байна.	Г
	3.Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллах.	Хугацаандаа тайлагнасан байна.	Г
	4.Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх, тайлагнах.	Холбогдох журам, зааврыг баримталсан байна.	Г
	5.Байгууллагын дүрэм, хөдөлмөрийн дотоод журам, үйлчилгээний стандарт, төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм, бусад холбогдох дүрэм, журмыг мөрдөж ажиллах.	Ёс зүйн зөрчилгүй ажилласан байна.	Г
	6.Удирдлагын шийдвэрээр байгуулгасан ажлын хэсэгт орж ажиллах.	Оролцоо хангагдсан байна.	Г
	7.Шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх, улс төрийн нөлөөлөл, авлига, ашиг сонирхлын зөрчлеөс ангид байх.	Хууль тогтоомжийг мөрдөн ажилласан байна.	Г
	8.Өөрийн мэдлэг, чадвараа байнга хөгжүүлэх.	Бие даан суралцсан байна.	Г

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Дээд боловсролтой		
Мэргэжил	Байгаль орчныг хамгаалах технологи, бэлчээр хамгаалал, нөхөн сэргээлт, байгаль орчны хяналтын үнэлгээ, байгалийн нөөцийн ашиглалт нөхөн сэргээлт		
Мэргэшил	Шаардлага тавихгүй		
Туршлага	Шаардлага тавихгүй		
Дүн шинжилгээ хийх	Дүн шинжилгээ хийх	-судалгааны арга зүйн мэдлэгтэй байх;	
		-албан ажлын хэрэгцээнд шаардагдах мэдээлэл цуглуулах, боловсруулах, харьцуулалт хийх, нэгтгэж дүгнэх, санал зөвлөмж боловсруулах;	
Асуудал шийдвэрлэх	Асуудал шийдвэрлэх	-гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах;	
		-бусад.	



Ур чадвар		урьдчилан харах чадвартай байх; -хууль, эрх зүйн үндэслэл бүхий зөвлөгөө өгөх чадвартай байх; -албан үүргээ мэргэжлийн түвшинд бүрэн хариуцах.
	Багаар ажиллах	-өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж хамтран ажиллах; -багийн хамт олны дунд хүлээсэн үүргээ гүйцэтгэх; -багийн зорилго, үйл ажиллагааг ойлгох, хүрээлэлд дасан зохицох, үр бүтээмжтэй ажиллах; -мэдлэг, туршлага, ур чадвараа бусадтай хуваалцах; -хамт олны зэрэг, нээлттэй уур амьсгалыг дэмждэг байх; -бусад.
	Бусад	-төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг мөрдлөг болгон ажиллах; -компьютерийн хэрэглээний текстэн, хүснэгтэн, үзүүлэн бэлтгэх программ болон мэдээллийн технологийн тоног төхөөрөмжийг ашиглах чадвартай байх; -төрийн албан хэрэг хөтлөлт, бичиг хэрэг, монгол хэл найруулгын чадвартай байх; -англи хэл эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийг ашиглах чадвартай байх.

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЬЕКТ

Албан тушаалыг шууд харьялан удирдах албан тушаалын нэр:

Сумын Засаг даргын Тамгын газрын дарга

<u>Албан тушаалд шууд харьялан удирдуулах албан тушаалын нэр, тоо:</u> Байхгүй	<u>Бусад харилцах субъект :</u> - нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагын холбогдох ажилтан - төрийн бус байгууллагын холбогдох ажилтан - төсөл, хөтөлбөрийн ажилтан - иргэн, хуулийн этгээд
---	--

V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

<u>Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:</u> Албан тушаал: ДОТООД АЖИЛ, ХҮНИЙ НӨӨЦ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Б.САЙНТУЯА (Гарын үсэг) (Эцэг/эх-/ийн нэр, өөрийн нэр) 2019 оны 07 дугаар сарын 16 -ны өдөр	<u>Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:</u> Байгууллагын нэр: ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ Шийдвэрийн огноо: 19 07 16 Дугаар: 40
--	---



Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:

Байгууллагын нэр:

БАЯН-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Шийдвэрийн огноо: 2019.10.31

Дугаар: 5/205

(тамга/тэмдэг)

ДАРГА ШӨЛЗИЙБАЯР

(Гарын/сэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)

2019 оны 10 дугаар сарын 21-ны өдөр

--Ооо--

